

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.23 № 101

танай _____ ны № _____ т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА Т.БАТТУЛГА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн өмчийн газрын нь 2025 онд А/02, А/34, А/39 дүгээр тушаалаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын тогтоолоор 103.4 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэн авч А/15, А/38 дугаар тушаалаар Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор 17.6 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг улсын орлого болгон хураан авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудлууд

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэгдэлгүй болсон 18 нэр төрлийн 35.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж 1.3 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

6326050017

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,702.20	15,071.31
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	145,240.27	179,704.33
	Нийт хөрөнгийн дүн	153,942.47	194,775.64
	Нийт өр төлбөрийн дүн	1,057.54	807.20
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	152,884.93	193,968.44
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	153,942.47	194,775.64
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	431,771.14	476,367.29
	Үйл ажиллагааны зардлын дүн	374,181.34	427,531.16
	Үйл ажиллагааны үр дүн	57,589.81	48,836.13
	Үйл ажиллагааны бус үр дүн	-16,799.07	-7,752.62
	Үйл ажиллагааны нийт үр дүн	40,790.73	41,083.51
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	116,044.20	152,884.93
	Тайлант оны үр дүн	0	41,083.51
	Эцсийн үлдэгдэл	116,044.20	193,968.44
Мөнгөн гүйлгээний тайлан			
		0	0
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	365,775.80	401,399.80
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	333,694.09	394,139.80
	Үйл ажиллагааны ЦМГ	32,081.71	7,260.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-32,081.71	-7,260.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		393,976.54
	Урсгал зардал		393,976.54
	Хөрөнгийн зардал		0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		0
	Улсын төсвөөс санхүүжих		398,399.80
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус газар нь “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн өмчийн харилцааг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх, өмч хувьчлах, хөрөнгө актлах, дахин үнэлэх, шилжүүлэх, шинээр бий болгох чиг үүрэгтэй, ОНӨААТҮГ-ын өмчийн харилцааны асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх, үндсэн хөрөнгийг данснаас хасах /худалдах, шилжүүлэх/, дахин үнэлэх болон санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээг холбогдох дэд шатны байгууллагад тайлагнаж ажиллаж ажиллахад оршино.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэн

Орон нутгийн өмчийн газрын нь 2025 онд А/02, А/34, А/39 дүгээр тушаалаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын тогтоолоор 103.4 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэн авч А/15, А/38 дугаар тушаалаар Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор 17.6 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг улсын орлого болгон хураан авч данс бүртгэлд тусгасан байна.

Тав. Аудитын гол асуудал

Орон нутгийн өмчийн газрын нь 2025 онд А/02, А/34, А/39 дүгээр тушаалаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын тогтоолоор 103.4 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэн авч А/15, А/38 дугаар тушаалаар Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор 17.6 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгслийг улсын орлого болгон хураан авч данс бүртгэлд тусгасан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг зохистой удирдаж зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг хийхгүй байх, Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн оруулж байх.

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 406,596.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 406,596.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,674.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр 2025 оны 05 дугаар сарын 05-аас 10-ны хооронд 5 хоног мэдээ тайлан хүлээн авах нэгдсэн цугларалт, сургалтад томилолтоор ажилласан боловч унааны зардал 80.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

8.2 Албан шаардлага

Шилэн дансны 406.6 сая төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн тул албан шаардлага хүргүүлээ.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

ОНӨГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Б/05 тушаалаар хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтаар байгууллагын дарга өөртөө тушаал гаргаж буцалтгүй тусламж авсан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр 2025.05.05-аас 10-ны хооронд 5 хоног мэдээ тайлан хүлээн авах нэгдсэн цугларалт, сургалтад томиллоор ажилласан боловч унааны зардал 80.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй.	1	80.0	1	80.0								
ОНӨГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Б/05 тушаалаар хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтаар байгууллагын дарга өөртөө тушаал гаргаж буцалтгүй тусламж авсан байна.	1	200.0					1	200.0				
Шилэн дансны 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.	1	406,596.6			1	406,596.6						
Дүн	3	406,876.6	1	80.0	1	406,596.6	1	200.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						